

Эрхэм хувьцаа эзэмшигчид ээ,

Өнгөрсөн жил манай компанийн хувьд онцгой амжилтын жил байлаа. Бид Монгол Улсын баруун өмнөд бүсэд орших өндөр агуулга бүхий алтны ордыг амжилттай хөгжүүлж, “Баянхөндий” алтны төслийг нээн илрүүлснээс хойш арван жилийн хугацаанд олборлолтын шат руу хөгжүүлсэн нь салбартаа хамгийн богино хугацаанд хэрэгжсэн төслүүдийн нэг болж байна.

Бид энэхүү амжилтаараа бахархахын зэрэгцээ, шинэчилсэн ТЭЗҮ-д тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх, Баянхөндий алтны уурхайн өсөлт, өргөтгөлийг дэмжих хүрээнд Хөндий Эрдсийн Дүүрэг дэх үйл ажиллагаагаа эрчимжүүлэн, тууштай ажиллаж байна. Баянхөндий алтны уурхайгаас бий болох мөнгөн урсгалд тулгуурлан нөөцөө нэмэгдүүлэх, төслийн багцаа урагшлуулах бодит боломж бүрдэж, ингэснээр компани болон түншүүдээ дараагийн хөгжлийн шатанд шилжүүлэх таатай байр сууринд байна. Өнгөрсөн арван жил амжилт бүтээлээр дүүрэн байсны адил ирэх арван жил ч Эрдэнэ Ресурсийн хувьд өсөлт, хөгжлөөр арвин байна гэдэгт бид итгэл төгс байна.

Баянхөндий — Шинэ алт олборлогч

Монгол Улсын баруун өмнөд хэсэгт орших Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд Эрдэнэ Ресурсийн геологичид өндөр агуулга бүхий алтны анхны дээжийг илрүүлснээс хойш даруй арван жил өнгөрчээ. Энэхүү нээлтийг баталгаажуулах зорилгоор хэрэгжүүлсэн анхны өрөмдлөгийн хөтөлбөрөөр өрөмдсөн 96 цооногийн 95-д алтны хүдэржилт огтолсон. 2018 оны эцэс гэхэд бид өндөр агуулга бүхий ордыг тодорхойлж, түүнээс хойш техникийн судалгаа, инженерчлэлийн ажлуудыг үе шаттайгаар гүйцэтгэн, бүтээн байгуулалтын бэлтгэл ажлыг хангаж эхэлсэн.



Эрдэнэ Ресурсийн хайгуулын баг – Баянхөндий ордын нээлт – 2016 он

2023 онд Монголиан Майнинг Корпорэйшн (“ММС”)-тэй стратегийн түншлэл байгуулсны дараа Баянхөндий алтны уурхайн бүтээн байгуулалтыг эхлүүлсэн. Төслийг хэрэгжүүлэгч Эрдэнэ Монгол ХХК-ийн хамт олон нь Баянхөндий төслийн барилга, инженерчлэл, худалдан авалтын цогц гэрээ (“ЕРС”)-г байгуулсан Эм Си Эс Проперти компанийн дэмжлэгтэйгээр ердөө 22 сарын хугацаанд боловсруулах үйлдвэр, туслах барилга байгууламжууд, уурхайн зам болон холбогдох дэд бүтцийг амжилттай барьж байгуулсан. Үүний зэрэгцээ ММС-ийн харилцан хамаарал бүхий Эм Си Эс Интернэйшнл ХХК нь 242 км урт цахилгаан дамжуулах шугамыг бүтээн байгуулж, уурхайн талбайг тогтвортой, харьцангуй бага өртөг бүхий эрчим хүчний эх үүсвэрээр хангах нөхцөлийг бүрдүүлсэн. Бүтээн байгуулалтын оргил үед төслийн талбайд 800 гаруй ажилтан ажиллаж, 2025 оны 9-р сард анхны алтыг үйлдвэрлэх хүртэл нийт 4 сая хүн/цагийг осолгүй, аюулгүй гүйцэтгэсэн.



Анхны алтыг олборлов – ЭМ ХХК-ийн Гүйцэтгэх захирал А.Билгүүн, ЭРД-ийн Гүйцэтгэх захирал Петер Акерли, ЭМ ХХК-ийн Өсөлт хөгжил хариуцсан захирал Жон Лёнс – 2025 оны 9-р сар

Анхны алт олборлолтоос 2026 оны 1-р улирлыг дуустал уурхай нийт 15 мянган унц алт үйлдвэрлэж, 100 сая канад долларын орлого бүрдүүлээд байна. Боловсруулах үйлдвэр төлөвлөсөн хүчин чадлаар ажиллаж, алт авалтын түвшин төлөвлөсөн 93%-аас давж 96%-д хүрсэн нь хүдрийн биетийн чанар, Эрдэнэ Монгол ХХК-ийн хамт олны мэргэжлийн ур чадварыг илтгэн харуулж байна.

Одоогоор боловсруулж буй хүдрийн дундаж агуулга 2.0 г/т орчим байгаа ба олборлолт тогтворжин, Эрдэнэ Монгол ХХК-ийн багийн туршлага нэмэгдэхийн хэрээр агуулга сайжрах хандлагатай байна. Зорилтот сургалт, олон улсын зөвлөхүүдийн дэмжлэг, тэсэлгээний ажлын оновчлол болон геологийн нэмэлт судалгааны үр дүнд сүүлийн хоёр сарын хугацаанд хүдрийн агуулга өсөж, зарим өдрүүдэд 4.0 г/т агуулгаас давсан үзүүлэлттэй байв.


Шинэчилсэн ТЭЗҮ-д уурхайн ашиглалтын долоон жилийн хугацаанд жилд дунджаар 74,000 унц алт олборлохоор төлөвлөсөн. Гэвч одоогийн ил уурхайн орчим дахь хэтийн төлөв бүхий

талбайн нөөцийг олборлолтод үе шаттайгаар оруулснаар уурхайн ашиглалтын хугацааг цаашид уртасгах боломжтой гэж үзэж байна. Мөн одоогоор овоолгод хуримтлуулж буй бага агуулга бүхий хүдрийг овоолгон уусгалтын технологиор боловсруулах боломжийг судалж байна.

Олон улсын статистикаас харахад, анхан шатны хайгуулын (“grassroots”) төслүүдийн нэг хүрэхгүй хувь нь уурхай болж хөгждөг. Энэ утгаараа Баянхөндий төсөл нь салбартаа ховор амжилтын жишээ бөгөөд Монгол Улсад төслийг зөвшөөрлийн үе шатнаас эхлэн бүтээн байгуулалт, арилжааны үйлдвэрлэлийн шатанд хүртэл амжилттай хэрэгжүүлэх бүрэн боломжтойг тодорхой харуулж байна. Энэхүү амжилтад үнэтэй хувь нэмэр оруулсан стратегийн түнш Монголиан Майнинг Корпорэйшн (“MMC”) болон түүний гол хувьцаа эзэмшигч Эм Си Эс Групп-тэй хамтран ажиллаж байгаадаа талархал илэрхийлье.

“Уурхай орчмын” тэлэлтийн боломжууд


Эрдэнэ Монгол ХХК нь Баянхөндий уурхайн ашиглалтын хугацааг уртасгах, боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор уурхайн орчим дахь Хар Морь, Баруун Хөндий зэрэг хэд хэдэн талбайн тэлэх боломжийг идэвхтэй судалж байна.



Хөндий алтны хувирлын тренд – Хөндий Эрдсийн Дүүрэг

Хар Морь талбай нь Баянхөндий ил уурхайгаас хойд зүгт 2 км зайд байрладаг бөгөөд тус талбайн төв хэсэгт ойролцоогоор 50,000 унц алтны нөөц бүхий маш өндөр агуулгатай орд

тогтоогдсон. Уг ордын олборлолтыг 2027 оноос эхлүүлэхээр төлөвлөж байна. Супергэнээр баяжуулсан энэхүү орд нь нийт гурван км үргэлжлэх хүдэржилтийн структурын бүсэд байрладаг.




Хар Морь талбай – 3км хүдэржсэн структур

Өмнөд Хар Морь талбайд гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөрөөр одоогийн төлөвлөсөн ил уурхайтай зэрэгцээ, тодорхойлогдсон нөөцөөс гадна бүсэд, газрын дөт гүнд өндөр агуулга бүхий интервалуудыг огтолсон. Үүнд: 9.6 г/т алтны агуулга бүхий 19 метр, 28.7 г/т алтны агуулга бүхий 3 метрийн интервалууд багтаж байна.

Хойд Хар Морь талбайд төлөвлөсөн уурхайн хязгаараас хойш 500 метрийн зайд исэлдсэн болон шилжилтийн бүсүүдэд хэд хэдэн алтны хүдэржилт огтолсон. Үүнд: 1.9 г/т алтны агуулга бүхий 43 метр, 1.4 г/т алтны агуулга бүхий 16 метрийн интервалууд багтаж байна. 700 метр үргэлжлэх энэхүү бүсэд исэлдсэн хүдэр 100 метр хүртэл гүнд тархсан ба харьцангуй бага агуулга бүхий хүдрийг Баянхөндий боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаатай уялдуулан нуруулдан уусгалтын технологиор боловсруулах боломжийг судалж байна. Энэ хүрээнд Хар Морь талбайн дээжийг Канад Улсын Бритиш Колумб муж дахь Блю Коуст судалгааны лабораторид хүргүүлэн, нуруулдан уусгалтын технологиор боловсруулахад тохирох эсэхийг тодорхойлох туршилтыг гүйцэтгэж байгаа ба үр дүнг ирэх саруудад хүлээн авна.

Хар Морь хагарлын бүстэй перпендикуляр чиглэлд үргэлжлэх Алтан Сум хүдэржилтийн структур нь 1.4 км-ийг хамран байрладаг. Энэхүү бүсэд хийгдэж буй хайгуулын ажил одоогоор эхний шатандаа байгаа хэдий ч исэлдсэн бүсийн үр дүн хэтийн төлөв өндөртэй харагдаж байна. Үр дүнгүүдэд: 1.3 г/т алтны агуулга бүхий 16 метр болон 66 г/т мөнгөний агуулга бүхий 5 метрийн интервалууд багтаж байна.



Баруун Хөндий бүс – Баянхөндийн хүдэржилтийн үргэлжлэл гэж тодорхойлогдсон

Мөн Баянхөндий ил уурхайг баруун чиглэлд тэлэх боломжийг судалж байгаа ба үүнд Баруун Страйкер бүсийг өргөтгөн уурхайн төлөвлөгөөнд нэгтгэх боломжийг сүүлийн үеийн өрөмдлөгийн үр дүн болон алтны үнийн өсөлтөд тулгуурлан үнэлж байна.

Баянхөндийн хүдэржилт баруун зүгт үргэлжлэн, Улаан тусгай зөвшөөрлийн талбай руу шилждэг ба энэ бүсэд гүйцэтгэсэн өрөмдлөгөөр Хөндий Эрдсийн Дүүрэг дэх хамгийн зузаан хүдэржилтийн бүсүүдийг огтолсон. Хүдэржилт нь 400 метр хүртэл гүнд үргэлжлэн, цооногийн эцэс хүртэл хүдэржилт үргэлжилсэн хэвээр байгааг тогтоосон. Эдгээр өргөн интервалууд дотор өндөр агуулга бүхий тэжээгч бүсүүд агуулагдаж байна.

Эрдэнэ Монгол ХХК-ийн эзэмшлийн Баянхөндий болон Улаан тусгай зөвшөөрлүүдийн дунд Монгол Улсын төрийн өмчит Эрдэнэс Алт компанийн эзэмшдэг Хүрэн Цав тусгай зөвшөөрөл байрладаг. Урт хугацаандаа энэхүү бүсийг хамарсан томоохон уурхайн төслийг хамтын ажиллагааны хүрээнд хөгжүүлэх боломжтой гэж үзэж байна.


Баянхөндий эпитеpmаль систем нь хоорондоо холбогдсон 10 гаруй км үргэлжлэх структурын дагуу тархсан ба хайгуулын хувьд харьцангуй эхний шатандаа байна. 2026 оны сүүлээр уурхай орчмын нэмэлт нөөцийг тусгасан Баянхөндий уурхайн шинэчилсэн олборлолтын төлөвлөгөөг танилцуулахаар ажиллаж байна. Одоогоор Хөндий болон Улаан тусгай зөвшөөрлийн талбайн зөвхөн 10%-ийг өрөмдлөгийн хөтөлбөрөөр шалгасан тул цаашдын хайгуулын хөтөлбөрүүдээр нөөцийг нэмэгдүүлж, өнөөгийн ТЭЗҮ-д тусгасан долоон жилийн ашиглалтын хугацааг уртасгах боломжтой гэж итгэж байна.

Алтан Нар – Хөгжлийн дараагийн тулгуур төсөл

Баянхөндий алтны уурхайн олборлолт эхэлснээр бид Баянхөндийн нээлтээс өмнө компанийн голлон төвлөрч ажиллаж байсан Алтан Нар төсөлд дахин анхаарал хандуулах боломжтой болж байна. Алтан Нар төслийг манай хайгуулын баг 2011 онд Палеозойн үеийн

порфир ба эпитермаль төрлийн алт-зэсийн системүүдэд тулгуурласан бүс нутгийн хайгуулын ажлын үр дүнд нээн илрүүлсэн.

Дөрвөн жилийн хугацаанд гүйцэтгэсэн хайгуулын ажлын хүрээнд тусгай зөвшөөрлийн талбайн 5.6 км х 1.5 км хүдэржсэн бүсийн дагуу 18 (алт, мөнгө, хар тугалга, цайр) хэтийн төлөв бүхий талбайг тодорхойлсон. Эдгээрээс эхний нээлтүүд болох “Нээлтийн Бүс” болон “Хойд Холбоо” талбайд өрөмдлөгийн ажлыг түлхүү төвлөрүүлсэн бол трендийн бусад хэсэгт хайгуул хязгаарлагдмал түвшинд хийсэн. Энэхүү систем нь карбонат суурь металлын томоохон ордууд болох Баррик Гоулдын Поргера уурхай, Рио Тинтогийн олборлож байсан Келиан уурхай, Лундинын Фрута Дел Норте, Зижин компанийн Буритика зэрэг ордуудтай төстэй геологийн тогтоцтой.



Алтан Нар орд – 5.6 км хүдэржсэн структур

2018 онд RPM Global нь Алтан Нар төслийн ашигт малтмалын нөөцийн тооцооллыг боловсруулж, 2.8 г/т алттай дүйцэх нэгж (453,000 алттай дүйцэх нэгж бүхий унц) бүхий агуулгатай 5.0 сая тонн хүдэр (Бодитой нөөц); 2.5 г/т алттай дүйцэх нэгж (277,000 алттай дүйцэх нэгж бүхий унц) бүхий 3.4 сая тонн хүдэр (Боломжтой нөөц)-ийг тооцоолсон. Өнөөгийн тодорхойлогдсон нөөцийн 90% нь газрын гадаргаас 150 метрийн гүн хүртэл байрлах бөгөөд гүн рүү болон суналын дагуу нээлттэй хэвээр байна. Түүнчлэн Алтан Нар тусгай зөвшөөрлийн талбайд Оюут Хөндий зэсийн илрэл, Номин Тал алт-зэсийн илрэл

бүхий талбай байрладаг. Эрдэнэ Монгол ХХК нь Баянхөндий төсөлд төвлөрөн ажилласантай холбоотойгоор эдгээр талбайд одоогоор өрөмдлөгийн ажил хийгээгүй байна.

Өмнө боловсруулсан техникийн тайлангаар Алтан Нар ордын үндсэн хүдрийг Баянхөндийн боловсруулах үйлдвэрт боловсруулах нь эдийн засгийн үр ашигтай гэж тооцоолсон. Одоогоор бид энэхүү хувилбарын хэрэгжих боломжийг дахин үнэлэх зорилгоор металлургийн нэмэлт туршилт, судалгааг гүйцэтгэж байна. Гэвч ордын цар хүрээ, тусгай зөвшөөрлийн талбайд хийгдсэн хайгуулын түвшин харьцангуй хязгаарлагдмал хийгдсэн байдал, мөн хүдрийн металлургийн онцлогийг харгалзан үзвэл Алтан Нар төслийн хүрээнд Баянхөндийтэй дүйцэх хэмжээний боловсруулах үйлдвэрийг бүтээн байгуулах боломжийг ч үгүйсгэхгүй. Энэхүү төслийг амжилттай хэрэгжүүлснээр Эрдэнэ Монгол ХХК-ийн алтны үйлдвэрлэлийг цаашид нэмэгдүүлэх боломж бүрдэх юм.

Зуун Мод – Ази тивд хөгжүүлэлт хийгдээгүй хамгийн том молибден, зэсийн ордуудын нэг


Баянхөндий ордоос зүүн зүгт 35 км-т орших Эрдэнэ Ресурсийн эзэмшлийн Зуун Мод порфирийн комплекс нь Ази тивд хөгжүүлэлт хийгдээгүй хамгийн том молибденийн төслүүдийн нэг юм.

2025 оны 10-р сард Эрдэнэ Ресурс нь Зуун Мод молибден-зэсийн ордын шинэчилсэн нөөцийн тооцооллыг танилцуулсан. Молибденийн Баттай болон Бодитой нөөц 22%-аар өсөж 333 сая фунт (“Mlbs”), Боломжтой нөөц 95%-аар өсөж, 300 сая фунт болсон. Зэсийн Баттай болон Бодитой нөөц 16% өсөж, 384 сая фунт (“Mlbs”), Боломжтой нөөц 75% өсөж 350 сая фунт болсон.

2025 оны сүүлээр Зуун Мод ордод 18 цооног өрөмдсөн ба ордын орчимд газрын дөт гүнд молибденийн хүдэржилтийн агуулгыг сайжруулж, баталгаажуулав. Энэхүү өрөмдлөгийн үр дүнгүүд болон уурхайн төлөвлөлт, металлургийн судалгаа, дэд бүтцийн төлөвлөгөө, боловсруулах загварчлалыг 2026 оны 3-р улиралд танилцуулах Анхан шатны эдийн засгийн тооцоололд багтаана.

Үүний зэрэгцээ зах зээлийн судалгаагаар молибден нь гангийн үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий түүхий эд төдийгүй дэвшилт технологи, сансрын болон батлан хамгаалахын салбарт эрэлт нь өсөн нэмэгдэж байна. Молибденийн зах зээлийн өсөлт давамгайл хэвээр байгаа ба Зуун Мод төслөөс үйлдвэрлэх бүтээгдэхүүн зах зээлд шингэх боломжтой гэж харж байна.


Цаашлаад Зуун Мод орд нь томоохон зэсийн порфирийн системийн гадаргад ойр байрлах хэсэг байж болзошгүй гэх геологийн таамаглал бий. 2025 оны сүүлээр ордоос баруун зүгт 4.5 км-т өрөмдсөн өрөмдлөгөөр энэхүү таамаглалыг дэмжсэн үр дүн гарсан. Энэ үр дүнд: 1.25% зэсийн хүдэржилт бүхий 30 метрийн интервал багтсан. Дээрх таамаглалыг үргэлжлүүлэн шалгах, гүн рүү өрөмдөх өрөмдлөгийн зорилтот бүсийг тодорхойлох зорилгоор энэ оны сүүлээр геофизикийн судалгаа гүйцэтгэхээр төлөвлөж байна. Бид Зуун Мод ордыг хөгжүүлэхийн зэрэгцээ энэхүү өргөн хүрээтэй томоохон системийг үргэлжлүүлэн судална.



Хөвийн Хар порфирийн систем (Зуун Мод ордыг агуулсан)

Тэрэг Уул – Томоохон тоглогчдын хамт

Өнгөрсөн оны 7-р сард бид Тэрэг Уул тусгай зөвшөөрлийн талбайн 80 хүртэл хувийг эзэмших боломжийг авах гэрээг Монголын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хийсэн. Энэхүү тусгай зөвшөөрлийн талбай нь ирээдүйн арван жилд дэлхийн хэмжээнд дөрөв дэх том зэсийн уурхай болох төлөвтэй Оюу Толгой зэсийн төслөөс урд зүгт 10 км-т байрлаж байна.



Тэрэг Уул зэс-алтны төсөл – Оюу Толгой дүүрэг, Өмнөговь

2025 оны хайгуулын хөтөлбөрөөр 2 км×800 метрийн хэмжээтэй талбайд алтны аномаль хүдэржилтийн бүсийг тогтоосон. Үүнээс гадна, тусгай зөвшөөрлийн талбайг хамарсан геофизикийн судалгаагаар хэд хэдэн зэсийн зорилтот бүсийг тодорхойлоод байна. Бид хэдэн долоо хоногийн өмнө тус талбайд анхны өрөмдлөгийн хөтөлбөрөө эхлүүлсэн бөгөөд үр дүнг 3-р улиралд танилцуулахаар төлөвлөсөн.

Сүүлийн 15 жилийн хугацаанд бид Хөндий Эрдсийн Дүүрэгт төвлөрч ажилласан хэдий ч Монгол Улсад үйл ажиллагаа явуулсан 20 гаруй жилийн түүхэндээ нийт 111 тусгай зөвшөөрөл эзэмшиж, Монгол Улсын 21 аймгийн 14-т нь хайгуул, судалгааны ажил хэрэгжүүлж байсан туршлагатай. Бид энэ туршлага дээрээ тулгуурлан ирээдүйд хэтийн төлөв бүхий талбайг тодорхойлж, төсөл хөтөлбөрүүдээ өргөжүүлнэ.

Хувьцаа эзэмшигчдийн дэмжлэг – Амжилтын үндэс

Өнгөрсөн оны 9-р сард бид хувьцаа нэгтгэх үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж, нийт гаргасан хувьцааны тоог зургаа дахин бууруулсан. Энэхүү алхмыг бид зах зээлийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, мөн үнэлгээ бага хувьцаанд хөрөнгө оруулах хязгаарлалттай томоохон хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх, цаашлаад Эрдэнэ Ресурсийн хувьцааг хөрөнгийн зах зээлийн индексүүдэд багтах бэлтгэлийг хангах зорилгоор хэрэгжүүлсэн. Хувьцааны нэгтгэлийг хэрэгжүүлснээр арилжааны идэвх, хөрвөх чадвар сайжирч, өдөр тутамд арилжаалагдаж буй хувьцааны үнийн дүн дунджаар дөрөв дахин өссөн.

2025 оны 12-р сард бид Торонтогийн Хөрөнгийн Биржид бүртгэл хийлгэсний 20 жилийн ойг тэмдэглэлээ. Мөн 2025 онд АНУ дахь бүртгэлээ OTCQX Best Market түвшинд ахиулснаар Америкийн хөрөнгө оруулагчдын хувьд арилжааны хөрвөх чадварыг сайжруулав. Түүнчлэн бид Монголын Хөрөнгийн Биржид давхар бүртгэлтэй цорын ганц компани хэвээр байгаа ба хувьцаа эзэмшигчдэдээ тогтмол дэмжлэг үзүүлдэгт чин сэтгэлийн талархал илэрхийлье.



Торонтогийн хөрөнгийн биржийн цан цохих ёслол – 2025 оны 12-р сар

2-р сард бид \$25 сая канад долларын хаалттай, тогтоосон үнээр худалдан авах баталгаа гаргасан санхүүжилтийг татан төвлөрүүлсэн. Энэхүү санхүүжилтээр компанийн гол хувьцаа эзэмшигчид хувь эзэмшлээ хадгалан оролцооноос гадна шинэ хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулж, манай хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд нэгдсэн. Татан төвлөрүүлсэн хөрөнгө оруулалтыг компанийн эзэмшлийн төслүүдийг эрчимтэй хөгжүүлэхэд зарцуулна. Баянхөндий ордоос бий болох мөнгөн урсгал нь Эрдэнэ Монгол ХХК-ийн үйл ажиллагаа болон төсөл хөтөлбөрүүдийг тэлэх, өргөжүүлэхэд зарцуулахын зэрэгцээ Эрдэнэ Ресурсийн хувьцаа эзэмшигчдэд өгөөжийг хүртээх суурь болно гэж үзэж байна.

Манай тогтвортой, урт хугацааны хөрөнгө оруулагчид нь компанийн амжилтын чухал хүчин зүйл байсаар ирсэн. Байгалийн баялаг, эрдсийн салбарт төвлөрсөн нэр хүндтэй хөрөнгө оруулагч ноён Эрик Спротт, манай томоохон хувьцаа эзэмшигчид, Канадын зүүн бүс дэх хувьцаа эзэмшигчид, Монголын хувьцаа эзэмшигчдийнхээ тууштай дэмжлэгт чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Ирээдүйн төлөв

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд Эрдэнэ Ресурс нь олон сорилтыг туулж, хайгуулын компаниас олборлогч компани болж амжилттай шилжлээ. Энэхүү чухал үе шатуудад аюулгүй, амжилттай хүргэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан нийт ажилтнууд, гэрээт гүйцэтгэгчид, хөрөнгө оруулагчид болон стратегийн түнш ММС-дээ гүн талархал илэрхийлье.

Баянхөндий уурхай нь тогтвортой мөнгөн урсгал бүрдүүлж эхэлснээр Хөндий Эрдсийн Дүүргийн хэмжээнд хайгуул болон хөгжүүлэлтийн ажлуудаа эрчимтэй урагшлуулах санхүүгийн боломж, суурийг тавилаа. Ирээдүйн олон арван жилийн тогтвортой өсөлтийн суурь нь Баянхөндий уурхайн ойролцоох тэлэх боломжууд, Алтан Нар болон Зуун Мод зэрэг төслүүдийн өсөлт хөгжил, ирээдүйн шинэ нээлтүүд юм.

Үнэт болон суурь металлын эрэлт дэлхий дахинд өсөн нэмэгдэж буй энэ үед өндөр чанартай эрдсийн нөөцөөр баялаг Хөндий Эрдсийн Дүүрэг нь Эрдэнэ Ресурсийн урт хугацааны амжилтын үндэс болж байна. Бид ирээдүйгээ өөдрөгөөр төсөөлөхийн зэрэгцээ бүтээж буй үнэ цэн, үр өгөөжөө нийт оролцогч талуудтайгаа хамтдаа хуваалцахдаа баяртай байна.

Эрдэнэ Ресурсийн хамт олны өмнөөс би хувьцаа эзэмшигчид, түншүүд, орон нутгийн иргэддээ бидэнд үргэлж итгэл хүлээлгэн, дэмжсээр ирсэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн,



Петер Акерли

Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал

Эрдэнэ Ресурс Девелопмент Корп.

Энэхүү захидалд Компанийн ирээдүйн санхүүгийн байдал, бизнесийн стратеги, Баянхөндий төслийн олборлолт, бүтээн байгуулалт болон ашиглалтад орох хугацаа, нөөцийн боломж, хайгуулын өрөмдлөг, олборлолтын үйл ажиллагаа, төсөвлөсөн санхүүгийн үр дүн, мөн ирээдүйд хэрэгжихээр хүлээгдэж буй үйл явдал, хөгжлийн талаарх тодорхой хэтийн төлөвийн мэдээлэл болон урьдчилсан таамаглал агуулсан болно. Түүхэн баримтаас бусад бүх мэдээгдэл нь хэтийн төлөвийн мэдээлэл, урьдчилсан таамаглалд хамаарна. “үзэж байна”, “хүлээж байна”, “харж байна”, “таамаглаж байна”, “төлөвлөж байна”, “тооцоолж байна”, “зорилт”, “үргэлжлүүлнэ”, “болзошгүй”, “байх болно” зэрэг үг хэллэгүүд нь урьдчилсан таамаглал илэрхийлнэ.

Дээр дурдсан урьдчилсан таамаглалаас гадна энэхүү захидалд дараах асуудлуудтай холбоотой урьдчилсан таамаглал багтсан болно. Үүнд: хайгуулын ажлын хүлээгдэж буй үр дүн; эрдэс баялгийн нөөцийн тооцоолол; шинэ эрдэс баялгийн нөөц илрүүлэх болон геологийн нөөцийг үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэх боломж; нэмэлт хөрөнгө татах болон ирээдүйн санхүүжилтүүдийг амжилттай хэрэгжүүлэх; хөрөнгө оруулалтын зардал болон урьдчилан тооцоолсон зардлууд; байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал болон бусад зохицуулалтын шаардлагыг хангах чадвар; үнэт металлын ирээдүйн үнэ; мөн Баянхөндийн алтны уурхайн үйл ажиллагаатай холбоотой шаардлагатай бүх зөвшөөрөл, лицензийг авах болон хүчинтэй хадгалах чадвар зэрэг (үүгээр хязгаарлагдахгүй) багтана.

Ийм төрлийн урьдчилсан таамаглал нь Компанийн зүгээс тухайн мэдээлэл, мэдэгдлийг гаргасан өдрийн байдлаар үндэслэлтэй гэж үзсэн тооцоолол, таамаглал дээр суурилсан боловч бизнес, эдийн засаг болон өрсөлдөөний тодорхойгүй байдал, эрсдэлүүдэд өртөмтгий байдаг. Эдгээр тооцоолол, таамаглалд тухайлбал: түүхий эдийн үнийн ноцтой өөрчлөлт гарахгүй байх; бизнес болон эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал мэдээгдэхүйц дордохгүй байх; Компанийн төлөвлөсөн үйл ажиллагаанд шаардлагатай гуравдагч талын гүйцэтгэгчид, тоног төхөөрөмж, ханган нийлүүлэлт болон төрийн болон бусад зөвшөөрлүүдийг боломжит нөхцөлөөр, шаардлагатай хугацаанд авах боломжтой байх; Компани болон түүний охин болон хараат компаниуд тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх; эрдэс баялгийн нөөц болон ашигт малтмалын нөөцийн тайлангийн үнэн зөв байдал; мөн банкны шаардлага хангасан ТЭЗҮ-д тусгагдсан бусад тооцоолол, таамаглалууд хамаарна.

Уншигчдад анхааруулахад, хэтийн төлөвийн мэдээлэл болон урьдчилсан таамаглал нь ирээдүйн үр дүнгийн баталгаа биш болно. Ийм мэдээлэл, мэдэгдэл үнэн зөв байх баталгаа байхгүй бөгөөд бодит үр дүн болон ирээдүйн үйл явдлууд нь эдгээр хэтийн төлөвийн мэдээлэлд тусгаснаас өөр байж болно. Хэтийн төлөвийн мэдээлэл болон урьдчилсан таамаглал нь бодит үр дүн, үйл явдлыг өөрчлөхүйц төрөл бүрийн эрсдэл, тодорхойгүй нөхцөл байдалд өртөмтгий байдаг. Үүнд: удирдлага болон мэргэжилтнүүдээс хамаарах байдал; эдийн засгийн нөхцөл байдал дордох эрсдэл; хайгуул болон бүтээн байгуулалтын бодит үр дүн хүлээлтээс муу гарах; өрсөлдөөн; зах зээлийн сөрөг хүчин зүйлс, тухайлбал ашигт малтмалын эрэлт болон борлуулалтын үнэ буурах; Компанийн хайгуул, бүтээн байгуулалт болон төлөвлөгөө биелэхгүй байх; улс болон орон нутгийн хууль тогтоомж, дүрэм журам, татвар, зохицуулалт болон бодлогын сөрөг өөрчлөлт; металлын үнийн хэлбэлзэл; валютын ханшийн өөрчлөлт; инфляц хүлээлтээс өндөр байх; уул уурхайн салбарын нийтлэг эрсдэлүүд; үйлдвэр, тоног төхөөрөмж болон боловсруулах үйлдвэр төлөвлөсний дагуу ажиллахгүй байх; ирээдүйн судалгааны урьдчилан таамаглаагүй үр дүн; улирлын шинж чанар болон цаг уурын гэнэтийн өөрчлөлт; зөвшөөрөл авах хугацаа төлөвлөснөөс удаашрах; байгаль орчны эрсдэл; нөхөн сэргээлтийн урьдчилан тооцоогүй зардал; эзэмшлийн маргаан, нэхэмжлэл; мөн Компанийн хамгийн сүүлийн жилийн мэдээллийн маягт болон бусад олон нийтэд ил болгосон баримт бичгүүдэд дурдсан эрсдэлт хүчин зүйлс зэрэг багтана. Эдгээр баримт бичгийг Компанийн www.erdene.com цахим хуудас болон SEDAR+, www.sedarplus.ca дахь Компанийн хуудсаас авах боломжтой.

Энэхүү захидал болон Компанийн бусад олон нийтэд ил болгосон баримт бичгүүдэд дурдсан эрсдэлт хүчин зүйлс нь Компанийн хэтийн төлөв, урьдчилсан таамаглалд нөлөөлж болох бүх хүчин зүйлийг бүрэн хамраагүй болно. Хэрэв эдгээр эрсдэл, тодорхойгүй нөхцөл байдал үүсэх, эсвэл үндсэн таамаглалууд зөрүүтэй гарах тохиолдолд бодит үр дүн нь урьдчилсан таамаглалд дурдсанаас мэдээгдэхүйц ялгаатай байж болно. Холбогдох хууль тогтоомжоор шаардсанаас бусад тохиолдолд Компани нь шинэ мэдээлэл, ирээдүйн үйл явдал болон бусад нөхцөл байдлын улмаас урьдчилсан таамаглалыг шинэчлэх, өөрчлөх ямар нэгэн үүрэг хүлээхгүй.

Компанийн Өсөлт хөгжил хариуцсан захирал Жон Лёнс (FAusIMM) нь Ашигт малтмалын төслийн мэдээлэл тайлагналын стандарт (NI 43-101)-д заасан “Мэргэшсэн этгээд” бөгөөд захидалд багтсан мэдээллийг компанийн өмнөөс хянан, баталгаажуулсан болно.

Энэхүү захидал нь англи хэл дээр бэлтгэгдсэн эх хувилбараас орчуулагдсан болно. Англи, монгол хувилбарын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарсан тохиолдолд англи хэл дээрх хувилбарыг баримтална.